



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/258

Улаанбаатар хот

“Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-тай
тооцоо хийх цэвэр, бохир усны үйлчилгээний
бөөний тариф мөрдөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дахь заалт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 102 дугаар тогтоол, Ус сувгийн удирдах газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ус хангамж, ариутгах татуургын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний бөөний тарифийг тооцохдоо Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан тарифыг даган мөрдсүгэй.

2. Батлагдсан цэвэр, бохир усны үйлчилгээний бөөний тарифыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга (Ц.Баянзул)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Эдийн засаг, санхүү бүртгэлийн хэлтэс (Ч.Ариунаа), Үйл ажиллагааны хяналтын хэлтэс (Д.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ТӨРХҮҮ



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Бүртгэлийн дугаар: 157

ХУУЛБАР ҮНЭН

Анх, Бүтээгч

(Хуульч/Хуульч ажилтан)

(Хуульч/Хуульч ажилтан)

(Хуульч/Хуульч ажилтан)

2023.10.24

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

“Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-тай тооцоо хийх цэвэр ус худалдан авах бөөний тарифыг НӨАТ-гүй 860 төг/м3, бохир ус татан зайлуулах бөөний тарифыг НӨАТ-гүй 548 төг/м3-ээр тус тус баталсугай.

3. Батлагдсан БОш-г тогтоосон хэмжээнд мөрдөхдөө инженер, техникийн болон мэргэжилтэй ажиллагсдын цалинг 25-аас доошгүй хувиар үе шаттайгаар нэмэгдүүлэх, ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны орлогын 0.3-аас доошгүй хувийг хүний нөөцийг чадавхижуулах зардалд зарцуулж ажиллахыг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ /Ч.Мэндбаяр/-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

5. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

У.УЛАМБАЯР

Х.ПҮРЭВСҮРЭН

142310056